



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Айраг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulhuuru@audit.gov.mn Аудитор: Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Аудит 03.20 № 16/343
танай _____ -ны № _____ -т

АЙРАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	949.6	1,276.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,653.2	9,254.4
	Нийт хөрөнгийн дүн	9,602.8	10,530.5
	Нийт өр төлбөрийн дүн	19.8	48.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,583.0	10,482.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,602.8	10,530.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,229.3	4,879.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,476.7	3,974.7
	Үйл ажиллагааны үр дүн	1,752.6	904.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	5.1	2.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,747.4	902.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,583.0	9,582.6
	Тайлант оны үр дүн		902.0
	Эцсийн үлдэгдэл	9,583.0	10,482.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,076.1	3,447.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,307.4	2,690.7
	Үйл ажиллагааны ЦМГ	768.7	756.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(667.9)	(558.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	100.8	198.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	162.9	263.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	263.7	461.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		2,988.4
	Урсгал зардал		2,495.6
	Хөрөнгийн зардал		492.8
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		3,189.2
	Улсын төсвөөс санхүүжих		2,134.9
	Орон нутгийн төсвөөс		924.4
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс		36.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		93.3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн үйлчилгээг хуульд нийцүүлэн, ил тод, хөнгөн шуурхай явуулахын зэрэгцээ нутаг дэвсгэрийн зохистой байршил, байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн давуу талд тулгуурлан, сумаа нийгэм эдийн засгийн хувьд бие даан хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх явдлыг эрхэм зорилго болгон тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр
- Нийгмийн бодлогын чиглэлээр
- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр
- Тогтвортой, хариуцлагатай, төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 147 мэдээллээс хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл байхгүй байна.

Нийт орлого зарлага болон тушаал шийдвэртэй холбоотой байршуулбал зохих бүх мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 алдаа, зөрчил илэрч, өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 70.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 53.1 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 17.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын татварын болон татварын бус орлогыг аймгийн ИТХ-аас 105.5 сая төгрөгөөр хянаж, сумын ИТХ-аар 136.0 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэл 232.6 сая төгрөг, үүнээс галт зэвсгийн албан татвар 0.3 сая төгрөгөөр тасарч, 11 нэр төрлийн орлого 96.9 сая төгрөгөөр давсан байна. Сумын ИТХ-аар хүү торгуулийн орлогыг 39.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан боловч гүйцэтгэлээр 75.1 сая төгрөгийн орлого орж 34.2 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвөөс 83.4 хувиар давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27.1.2-т “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн орлогыг өмнөх жилийн гүйцэтгэл болон бодит тоон мэдээлэлд үндэслэн төлөвлөх, батлах

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Айраг сумын Засаг дарга	1	1	-	-	1	-	-	-
НИЙТ		1	1			1			

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								Дүгнэлт
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
1	ИТХ	2	0.3	1	0.3	-	-	-	-	1	-	Зөрчилгүй
2	ЗДТГ	4	11.0	3	11.0	-	-	-	-	1	-	Зөрчилгүй
3	ЭМТ	2	7.6	2	7.6	-	-	-	-	-	-	Зөрчилгүй
4	ЕБС	2	1.9	1	1.1	-	-	-	-	1	0.8	Зөрчилгүй
5	Цэцэрлэг	1	0.2	1	0.2	-	-	-	-	-	-	Түүвэр
6	Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-	-	-	Түүвэр
7	СХС	-	-	-	-	-	-	-	-	-	-	Түүвэр
8	ОНХС	2	49.6	1	32.9	-	-	-	-	1	16.7	Түүвэр
9	ТТЗ-ийн нэгтгэл тайлан	1	-	-	-	-	-	-	-	1	-	Зөрчилгүй
	НИЙТ	14	70.6	9	53.1	-	-	-	-	5	17.5	